

**ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ  
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагч Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, зорилтууд, эдийн засгийн өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдол, үр ашиг бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслүүдийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд хэрэгжих, гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслүүдийн гадаад зээлийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг өргөн мэдүүлсэн төсөлд Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хассанаар өмнө өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслүүдэд өөрчлөлт орсон эсэх талаар асуулт асууж, өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахгүйгээр батлах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Н.НАРАНБААТАР**